



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ус цаг уур орчны шинжилгээний төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БӨА-2022/173/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Өлгий хот 2022 он</p>	<p>Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: М.Хуанган Утас: 70422954 Цахим хаяг: khuanganm@audit.gov.mn Аудитын менежер: Х.Женисбек Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn Аудитор: Ж.Назгүл Утас: 99668909 Цахим хаяг: nazgulj@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	Error! Bookmark not defined.
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	14
3.8 Аудитын гол асуудал	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

Төсвийн захирагч



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

АЙМГИЙН УС, ЦАГ УУР, ОРЧНЫ
ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН ДАРГА
П.ЖАНАРГУЛ ТАНАА

2022.02.08 № 23
танай _____-ны № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.ХУАНГАН

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>309,153,291.14</u>	<u>314,111,495.46</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
32	БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	-	-
33	АВЛАГА	-	-
34	УРЬДЧИЛГАА	-	-
35	БАРАА МАТЕРИАЛ	309,153,291.14	314,111,495.46
351	Түүхий эд материал	282,168,708.14	289,246,297.46
35110	Тусгай зориулалттай материал	282,168,708.14	289,246,297.46
354	Хангамжийн материал	26,984,583.00	24,865,198.00
35410	Бичиг хэргийн материал	2,797,679.00	2,913,779.00
35420	Аж ахуйн материал	24,186,904.00	21,951,419.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>510,483,696.74</u>	<u>591,272,651.36</u>
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	-	-
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	510,483,696.74	591,272,651.36
391	Газар		
392	Биет хөрөнгө	441,575,496.74	522,089,451.36
39201	Барилга, байгууламж, орон сууц	393,733,253.13	423,563,253.13
39202	Хуримтлагдсан элэгдэл	(35,999,114.29)	(54,556,633.40)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	72,267,573.78	72,267,573.78
39204	Хуримтлагдсан элэгдэл	(24,596,434.88)	(33,974,363.84)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	163,115,062.31	158,042,557.10
39206	Хуримтлагдсан элэгдэл	(134,655,788.60)	(51,454,860.85)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	31,287,373.09	27,822,235.27
39208	Хуримтлагдсан элэгдэл	(23,576,427.80)	(19,620,309.83)
393	Биет бус хөрөнгө	68,908,200.00	69,183,200.00
39301	Програм хангамж	-	-
39302	Хуримтлагдсан элэгдэл		
39303	Бусад биет бус хөрөнгө	69,579,800.00	69,854,800.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(671,600.00)	(671,600.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>819,636,987.88</u>	<u>905,384,146.82</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>-</u>	<u>-</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>819,636,987.88</u>	<u>905,384,146.82</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	819,636,987.88	905,384,146.82
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	401,209,193.75	401,209,193.75
51101	Өмч: - төрийн	401,209,193.75	401,209,193.75
512	Хуримтлагдсан үр дүн	164,459,225.68	253,937,584.62
51210	Өмнөх үеийн үр дүн	76,388,737.40	168,190,425.68
51220	Тайлант үеийн үр дүн	88,070,488.28	85,747,158.94
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	253,968,568.45	250,237,368.45
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>819,636,987.88</u>	<u>905,384,146.82</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,501,449,989.27	1,389,552,330.55
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	139,023,103.27	120,800,363.95
120	Нийтлэг татварын бус орлого	139,023,103.27	120,800,363.95
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	139,023,103.27	120,800,363.95
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	139,023,103.27	120,800,363.95
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,362,426,886.00	1,268,751,966.60
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,354,274,800.00	1,235,597,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,354,274,800.00	1,235,597,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,152,086.00	33,154,266.60
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,900,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,900,486.00	32,423,065.60
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	351,600.00	731,201.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,413,379,500.99	1,303,805,171.61
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,413,379,500.99	1,303,805,171.61
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,260,218,100.99	1,253,960,170.61
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,008,330,000.00	1,008,240,000.00
210101	Үндсэн цалин	693,381,600.00	695,273,300.00
210102	Нэмэгдэл	283,503,500.00	281,521,800.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	31,444,900.00	31,444,900.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	136,112,400.00	126,833,400.00
210201	Тэтгэврийн даатгал	95,782,800.00	87,800,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	10,082,400.00	10,082,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,065,900.00	8,065,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,016,500.00	2,016,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	20,164,800.00	18,867,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	34,658,500.00	28,225,800.00
210301	Гэрэл, цахилгаан	4,681,200.00	2,936,300.00
210302	Түлш, халаалт	29,538,200.00	24,911,800.00
210303	Цэвэр, бохир ус	439,100.00	377,700.00
2104	Хангамж, бараа материалын зардал	14,224,641.79	17,731,665.78
210401	Бичиг хэрэг	828,300.00	508,300.00
210402	Тээвэр, шатахуун	8,751,686.00	6,498,065.60
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,807,700.00	2,043,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,178,970.00	997,520.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		
210408	Бараа материал акталсны зардал	1,657,985.79	7,684,180.18
2105	Нормативт зардал	419,900.00	363,900.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	419,900.00	363,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,850,140.00	2,494,962.60
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,518,700.00	2,208,362.60
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	320,800.00	286,600.00

210604	Урсгал засвар	10,640.00	
2107	Томилолт, зочны зардал	5,902,400.00	3,731,900.00
210702	Дотоод албан томилолт	5,902,400.00	3,731,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,599,700.00	22,966,206.85
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,023,300.00	20,639,045.85
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	420,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	346,500.00	346,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	77,400.00	77,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	29,700.00	29,700.00
210807	Газрын төлбөр	122,800.00	183,200.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх		1,270,361.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	49,120,419.20	43,372,335.38
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,321,745.60	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	74,000.00	203,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	37,724,673.60	43,168,435.38
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	153,161,400.00	49,845,001.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	151,679,590.00	40,461,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	151,679,590.00	40,461,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,481,810.00	9,384,001.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,481,810.00	9,384,001.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	88,070,488.28	85,747,158.94
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	88,070,488.28	85,747,158.94

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	401,209,193.75	254,696,668.45	75,660,637.40	-	731,566,499.60
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			728,100.00		728,100.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	401,209,193.75	254,696,668.45	76,388,737.40	-	732,294,599.60
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					-
C07	Тайлант үеийн үр дүн	-		88,070,488.28		88,070,488.28
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	401,209,193.75	253,968,568.45	164,459,225.68	-	819,636,987.88
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	401,209,193.75	253,968,568.45	164,459,225.68	-	819,636,987.88
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			3,731,200.00		3,731,200.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	401,209,193.75	253,968,568.45	168,190,425.68	-	823,368,187.88
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		(3,731,200.00)			(3,731,200.00)
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					-
D08	Тайлант үеийн үр дүн			85,747,158.94		85,747,158.94
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	401,209,193.75	250,237,368.45	253,937,584.62	-	905,384,146.82

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,362,426,886.00</u>	<u>1,268,751,966.60</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,362,426,886.00	1,268,751,966.60
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,354,274,800.00	1,235,597,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,354,274,800.00	1,235,597,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,152,086.00	33,154,266.60
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,900,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,900,486.00	32,423,065.60
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	351,600.00	731,201.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>1,362,426,886.00</u>	<u>1,238,921,966.60</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,362,426,886.00	1,238,921,966.60
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,209,265,486.00	1,189,076,965.60
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,008,240,000.00	1,008,240,000.00
210101	Үндсэн цалин	693,291,600.00	695,273,300.00
210102	Нэмэгдэл	283,503,500.00	281,521,800.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	31,444,900.00	31,444,900.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	136,112,400.00	126,833,400.00
210201	Тэтгэврийн даатгал	95,782,800.00	87,800,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	10,082,400.00	10,082,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,065,900.00	8,065,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,016,500.00	2,016,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	20,164,800.00	18,867,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,550,000.00	28,412,800.00
210301	Гэрэл, цахилгаан	3,271,200.00	3,123,300.00
210302	Түлш, халаалт	28,839,700.00	24,911,800.00
210303	Цэвэр, бохир ус	439,100.00	377,700.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,547,086.00	10,226,065.60
210401	Бичиг хэрэг	731,800.00	624,400.00
210402	Тээвэр, шатахуун	8,751,686.00	6,498,065.60
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,057,200.00	2,043,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,006,400.00	1,060,000.00
2105	Нормативт зардал	419,900.00	363,900.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		
210502	Хоол, хүнс		
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	419,900.00	363,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,026,500.00	1,443,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,705,700.00	1,157,100.00
210602	Тавилга		
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	320,800.00	286,600.00
210604	Урсгал засвар	-	-

2107	Томилолт, зочны зардал	6,600,900.00	3,731,900.00
210701	Гадаад албан томилолт		
210702	Дотоод албан томилолт	6,600,900.00	3,731,900.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,379,200.00	9,421,300.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,802,800.00	8,364,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		420,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	346,500.00	346,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	77,400.00	77,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	29,700.00	29,700.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	122,800.00	183,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	389,500.00	403,900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	389,500.00	403,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	153,161,400.00	49,845,001.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	151,679,590.00	40,461,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	151,679,590.00	40,461,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,481,810.00	9,384,001.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,481,810.00	9,384,001.00
213304	Хөрөнгийн		
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-	29,830,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	29,830,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	29,830,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	29,830,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		29,830,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	(29,830,000.00)

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,235,597,700.00	1,226,318,700.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,235,597,700.00	1,226,318,700.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,195,136,700.00	1,185,857,700.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,008,240,000.00	1,008,240,000.00
210101	Үндсэн цалин	695,273,300.00	695,273,300.00
210102	Нэмэгдэл	281,521,800.00	281,521,800.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	31,444,900.00	31,444,900.00

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	136,112,400.00	126,833,400.00
210201	Тэтгэврийн даатгал	95,782,800.00	87,800,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	10,082,400.00	10,082,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,065,900.00	8,065,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,016,500.00	2,016,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	20,164,800.00	18,867,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,412,800.00	28,412,800.00
210301	Гэрэл, цахилгаан	3,123,300.00	3,123,300.00
210302	Түлш, халаалт	24,911,800.00	24,911,800.00
210303	Цэвэр, бохир ус	377,700.00	377,700.00
210304	Байрны түрээс		
2104	Хангамж, бараа материалын зардал	8,146,800.00	8,146,800.00
210401	Бичиг хэрэг	624,400.00	624,400.00
210402	Тээвэр, шатахуун	5,255,000.00	5,255,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,493,600.00	1,493,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	773,800.00	773,800.00
2105	Нормативт зардал	363,900.00	363,900.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	363,900.00	363,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,443,700.00	1,443,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,157,100.00	1,157,100.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	286,600.00	286,600.00
210604	Урсгал засвар	-	-
2107	Томилолт, зочны зардал	3,731,900.00	3,731,900.00
210701	Гадаад албан томилолт		
210702	Дотоод албан томилолт	3,731,900.00	3,731,900.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,281,300.00	8,281,300.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,224,500.00	7,224,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	420,000.00	420,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	346,500.00	346,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	77,400.00	77,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	29,700.00	29,700.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		
210807	Газрын төлбөр	183,200.00	183,200.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх		
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	403,900.00	403,900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	403,900.00	403,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	40,461,000.00	40,461,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	40,461,000.00	40,461,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	40,461,000.00	40,461,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,235,597,700.00	1,226,318,700.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,235,597,700.00	1,226,318,700.00

131001	Улсын төсвөөс санхүүжих	1,235,597,700.00	1,226,318,700.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	85.00	85.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	74.00	74.00
620003	Үйлчлэх ажилтан	8.00	8.00
620004	Гэрээт ажилтан	2.00	2.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	85.00	85.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	83.00	83.00
650010	Гэрээт ажилтан	2.00	2.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)		

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	33,049,265.60
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,219,265.60
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,219,265.60
2104	Хангамж, бараа материалын зардал	2,079,265.60
210401	Бичиг хэрэг	
210402	Тээвэр, шатахуун	1,243,065.60
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	550,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	286,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,140,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,140,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	29,830,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	29,830,000.00
221001	Их засвар	29,830,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	33,049,265.60
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	33,049,265.60
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	32,423,065.60
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	626,200.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Ус цаг уур орчны шинжилгээний төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Назгүл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Ус цаг уур орчны шинжилгээний төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баян-Өлгий аймаг дахь төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн 14 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Ус цаг уур орчны шинжилгээний төвийн зорилго нь: “Ус цаг уур, орчны хяналт шинжилгээ, мэдээлэл үйлчилгээний ажлыг батлагдсан хөтөлбөр, заавар, журмын дагуу гүйцэтгэх, мэдээ, мэдээллээр аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийг хангах”.

“Ус цаг уур орчны хяналт шинжилгээний ажлын тасралтгүй байдал, технологийн мөрдөлтийг хэрэгжүүлэх, салбар нэгжийг мэргэжил арга зүйгээр хангах, ажиллагсдын мэдлэг чадварыг дээшлүүлэх, ажиллах орчин нөхцөлийг сайжруулах” гэсэн зорилтын хүрээнд Ус, цаг уур, байгаль орчны мэдээ, мэдээллийг хэрэглэгчдэд үнэн зөв, түргэн шуурхай хүргэх, байгаль цаг агаарын болзошгүй аюул, гамшгаас аж ахуйн нэгж, байгууллага, ард иргэдийг сэрэмжлүүлэх, Ус цаг уур, орчны мэдээллээр нийгмийн хэрэгцээг хангах чиг үүргийг хэрэгжүүлэн ажилладаг.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

ЦУОШГазарт санхүүгийн дотоод аудитор болон үйл ажиллагаа хариуцсан 2 ажилтантай дотоод аудитын нэгжтэй бөгөөд тайлант онд аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвд хяналт шалгалт хийгээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ус цаг уур орчны шинжилгээний төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт хөрөнгийн сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт хөрөнгийн 819.6 сая төгрөгөөс 1 хувиар буюу 8.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 6.6 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 85.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага			
Урьдчилгаа			
Бараа материал	309153.3	314111.5	4958.5
Үндсэн хөрөнгө	510483.7	591272.6	80788.9
Нийт хөрөнгө	819637.0	905384.1	85747.1
Өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	89637.0	905384.1	85747.1
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	819637.0	905384.1	85747.1

Мөнгөн хөрөнгө, авлагын данс үлдэгдэлгүй байна. Бараа материалын дансны үлдэгдэл 314.1 сая төгрөг болж 4.9 сая төгрөгөөр өссөн нь Цаг уур орчны шинжилгээний газраас 26.6 сая төгрөгийн тусгай зориулалтын материалыг үнэгүй хүлээн авсантай холбоотой байна. Мөн тус газрын даргын 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/14 дугаар тушаалаар 4.8 сая төгрөгийн тусгай зориулалтын материал, 2.8 сая төгрөгийн аж ахуйн материал, нийт 37.1 сая төгрөгийн бараа материалыг актлах шийдвэр гаргаж акталсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 591.3 сая төгрөг болж 80.8 сая төгрөгөөр өссөн нь үнэгүй ирсэн үндсэн хөрөнгөтэй холбоотой байна. Цаг уур орчны шинжилгээний газраас 10.2 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг үнэгүй хүлээн авч данс бүртгэлд тусгасан байна. Мөн элэгдлээ бүрэн нөхөж дууссан 96.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 6.4 сая төгрөгийн тавилга эд хогшил, нийт 102.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2021 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 508 дугаар тогтоолоор 83.7 сая төгрөгөөр дахин үнэлж балансад тусгасан байна.

Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын 2021 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн А/126 дугаар тушаалаар 15.0 сая төгрөгийн конторын барилгын дээврийн их засвар, 10 дугаар сарын 05-ны өдрийн А/160 дугаар тушаалаар Алтай сумын цаг уурын өртөөний барилгын 14.8 сая төгрөгийн их засварын ажлыг барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын дүгнэлтийн дагуу хөрөнгө бүртгэлд тусгасан байна.

Тайлант хугацаанд өр төлбөр гараагүй байна. Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 905.4 сая төгрөг болж өмнөх оны үлдэгдлээс 85.7 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны анх батлагдсан төсөв 1241.1 сая төгрөг, тодотгосон төсөв 1235.6 сая төгрөг байна.

Тодотгосон төлөвлөгөө нь анх баталсан төлөвлөгөөнөөс 5.5 сая төгрөгөөр буурсан дүнтэй байна. Үүнд: Гэрэл цахилгааны зардлыг 1.3 сая төгрөгөөр, түлш халаалтын зардлыг 2.7 сая төгрөгөөр, хангамж бараа материалын зардлыг 0.6 сая төгрөгөөр, томилолтын зардлыг 0.5 сая төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 0.2 сая төгрөгөөр бууруулж тодотгосон байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 1235.6 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулж, гүйцэтгэлээр үйл ажиллагаандаа 1226.3 сая төгрөгийг зарцуулжээ.

Батлагдсан төлөвлөгөөг гүйцэтгэлтэй харьцуулж судалж үзэхэд төсвийг нийт дүнгээр 9.3 сая төгрөгөөр хэмнэж төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Нийгмин даатгалын шимтгэлийн зардлыг 9.3 сая төгрөгөөр хэмнэсэн байна. Шалтгааныг тодруулахад: 2021 оны 7 дугаар сарын 01-ээс нийгмин даатгалын шимтгэлийн ажил олгогчоос төлөх 1 хувь, даатгуулагчаас төлөх 1 хувь, нийт 2 хувийг бууруулсантай холбоотой гарсан хэмнэлт байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд дээд шатны байгууллагаас нийт 32.4 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авсан бөгөөд үүнээс 29.8 сая төгрөгт их засвар хийж, 0.8 сая төгрөгийг Алтай таван богдын барилгын бэхэлгээ хийлгэсний төлбөрт, 1.2 сая төгрөгийг судалгааны үлдэгдэл мөнгө, 0.6 сая төгрөгийг wifi төхөөрөмжийн үнэд зарцуулсан байна.

Тус төв нь агаар, ус, хөрсний шинжилгээ хийдэг бөгөөд тайлант онд шинжилгээний төлбөрт 0.6 сая төгрөгийн орлого оруулж, журмын дагуу үйл ажиллагаандаа зарцуулсан байна. Мөн нэмэлт дансаар 0.1 сая төгрөгийн цахим тендерийн мөнгөн төлбөр орж ирснийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2021 оны санхүүгийн тайланд холбогдох бүх мэдээллийг толилуулж, тодруулсан байна. Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүссэн тохиолдол гараагүй байна.

Тайлант онд тус төвөөс 2 ажилтан өндөр насны тэтгэвэрт гарч оронд нь 2 ажилтан шинээр томилсон байна. Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 105 дугаар тогтоолын хавсралтад Цаг уур, орчны шинжилгээний газрыг тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын хариу арга хэмжээнд оролцох, дэмжлэг үзүүлэх, томилгоот, жижүүрлэлтийн байгууллагад хамруулсан тул дээд газраас зөвшөөрсөнтэй холбоотой байна.

3.8 Аудитын гол асуудал

АОУС 701.8-д тодорхойлсон аудитын гол асуудлын хүрээнд 2021 оны санхүүгийн тайланд үлэмж нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл гараагүй байна.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд нөлөө бүхий ажил гүйлгээ гараагүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Ус цаг уур, орчны шинжилгээний төв нь 2021 онд нийт 1305.9 сая төгрөгийн 122 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 1305.9 сая төгрөгийн мэдээллийг ил тод байршуулсан байна. **Харин 2021 оны** аудитын тайланг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулаагүй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Ус цаг уур орчны шинжилгээний төв нь 2021 онд 1235.6 сая төгрөгийн батлагдсан төсвөөр, төсөвтөө багтаан үйл ажиллагаа явуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, батлагдсан төсвийн зарцуулалт нь төсвийн тухай хууль тогтоомжийг холбогдох заалтуудад нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн аудитаар унаа хоолны хөнгөлөлтийн зардалд 31.4 сая төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 89.6 сая төгрөгийг зарцуулсан бөгөөд цалингийн зардлын хэмнэлтээс 58.2 сая төгрөгийг холбогдох дээд байгууллагын зохих зөвшөөрөлгүйгээр төсвийн шууд захирагчийн тушаал болон төвийн даргын дэргэдэх зөвлөлийн хурлын тэмдэглэлийг үндэслэн зориулалт бусаар зарцуулсан зөрчилд албан шаардлага, шилэн дансны мэдээлэлтэй холбоотой 1 зөвлөмж хүргүүлсэн бөгөөд албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг УЦУОШТөвийн 2021.10.14-ний өдрийн 96 тоот албан бичгээр ирүүлжээ.

Тайлант онд цалингийн зардлыг зориулалтын дагуу зарцуулж, хэмнэлтийг төсөвт төвлөрүүлж албан шаардлагыг, шилэн дансны мэдээллийг бүрэн байршуулж зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал хандуулах зүйл гараагүй

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар алдаа зөрчил гараагүй болно.

4.1 Залруулсан алдаа

Залруулсан алдаа байхгүй

4.2 Төлбөрийн акт

Тогтоосон төлбөрийн акт байхгүй

4.3 Албан шаардлага

Албан шаардлага байхгүй

4.4 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөгдөөгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн